

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

№ Т-26/01

Улаанбаатар хот

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭЭХ”) 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий Сайд Амарын Гудамж-2 тоот хаягт Галлериа Улаанбаатар төв (Galleria Ulaanbaatar Center)-ийн 3 давхар, Juulchin Grand Ballroom танхимд зохион байгуулагдав.

ХЭЭХ-д оролцсон албан тушаалтнууд:

- ХЭЭХ-ын дарга, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дарга О.Болдбаатар,
- Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр,
- Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн бөгөөд Засаглал, нэр дэвшүүлэх хорооны дарга С.Боргил,
- Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл ба Байгаль орчин, нийгэм засаглал (цаашид “БОНЗ”)-ын удирдлагын хорооны дарга бөгөөд Цалин урамшууллын хорооны дарга С.Нэргүй,
- ХЭЭХ-ын Тооллогын комиссын дарга, “Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс” ХХН-ийн партнер, өмгөөлөгч С.Батбуян,
- ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга, Компанийн Үйл ажиллагааны газрын захирал М.Түвшинжаргал,
- Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Хулан нар оролцож, ХЭЭХ-ыг зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал хөтлөн явуулав.

ХЭЭХ-ын ирц: Нийт саналын эрх бүхий хувьцааны **81.65%**

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн болсон байна.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хүмүүсийг танилцуулъя.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга О.Болдбаатар;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Аудитын хорооны гишүүн С.Боргил;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хорооны дарга бөгөөд Цалин урамшууллын хорооны дарга С.Нэргүй;

Тооллогын комиссын дарга “Өмгөөллийн ЭмДиЭс энд ХаанЛекс ХХН”-ийн Партнер С.Батбуян;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Хулан;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал, Хурал зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал миний бие тус тус оролцож байна.

Ингээд хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийн дагуу Хурлын ирцийг мэдээлнэ үү хэмээн Тооллогын комиссын дарга С.Батбуян таныг индэрт урьж байна.

Тооллогын комиссын дарга С.Батбуян :

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид маань хурлын танхимд хүрэлцэн ирж хурал зохион байгуулагчдаас санал өгөх цахим хуудаст хандаж саналаа өгөх нэвтрэх нэр, нууц үгийг авснаар саналын эрх бүхий хувьцаа эзэмшигч нарын ирцийг бүртгэсэн байна.

Хувьцаа эзэмшигч та бүхэнд ирц бүртгүүлэхэд олгосон мандатад буй QR кодыг уншуулан <https://survey.lend.mn/> цахим хуудсанд өөрийн гар утас болон компаниас бэлтгэсэн компьютерыг ашиглан саналаа өгөх боломжтой. Та саналаа урьдчилан өгөх боломжтойгоос гадна ХЭЭХ-аар хэлэлцэх асуудал тус бүрийг танилцуулж, асуулт, хариулт, хэлэлцүүлэг явагдсаны дараа <https://survey.lend.mn/> цахим хуудсаар санал хураалт явагдана. Хэрэв саналаа урьдчилан өгсөн бол энэ хэсэгт дахин санал өгөх боломжгүй. ХЭЭХ-ийн дэгийн дагуу санал хураалтын хугацаа дуусахад санал хураалтын цахим хуудас хаагдах тул үүнээс хойш санал өгөх боломжгүй болох ба та санал өгөх системд саналаа бүрэн гүйцэд, зөв бөглөөгүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасны дагуу саналын хуудас хүчингүйд тооцогдоно гэдгийг та бүхэн анхаараарай.

Ингээд та бүхэнд “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн мэдээг танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчид маань 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цаг хүртэл брокер, дилерийн компаниудаар дамжуулан санал өгөх боломжтой байсан. Шалгаж үзэхэд “Ард Секюритиз ҮЦК” ХХК-иас 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хувьцаа эзэмшигч Ц.Чанцалхүүгээс ирүүлсэн саналын хуудсыг Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комисст ирүүлсэн бөгөөд тус саналыг энэхүү хурлын ирцэд тооцсон болохыг тэмдэглэж байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий хувьцааны **81.65** хувийг эзэмшиж байгаа **107** хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирж бүртгүүлсэн байх тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт зааснаар ХЭЭХ хуралдуулах ирц бүрдэж, ХЭЭХ хүчин төгөлдөр болж байгааг хувьцаа эзэмшигчид болон ХЭЭХ-ын даргад мэдээлж байна.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Тооллогын комиссын дарга С.Батбуяндаа баярлалаа.

Одоо та бүхний өмнө “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга О.Болдбаатар таныг Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулна уу хэмээн индэрт урьж байна.

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

Эрхэм хүндэт Хувьцаа эзэмшигчид ээ!

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Компанийн нийт хамт олны нэрийн өмнөөс хүргэе.

2025 он “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд хувьд өсөлт хөгжил, хариуцлагын шинэ шатанд гарсан онцгой жил байлаа. Тус оны онцлох үйл явдлаас товч дурдвал:

1. ЛэндМН нь 2024 онд Монгол Улсад анх удаа технологийн шийдлийг ашиглан нэмэлт бичиг баримт, барьцаа хөрөнгө шаардлагагүйгээр ердөө 5 минутын дотор бизнесийн зээлийг дансандаа хүлээн авах "Flexi Business" хэмээх цоо шинэ

санхүүгийн бүтээгдэхүүнийг үйлчилгээндээ нэвтрүүлсэн билээ. Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэдээ зориулсан тус Flexi Business зээлийн бүтээгдэхүүн нь богино хугацаанд хэрэглэгчдийн итгэлийг хүлээж, бизнес эрхлэгчдийн өдөр тутмын үйл ажиллагаа, бизнесийн өсөлтөд бодит дэмжлэг үзүүлэх, санхүүгийн хэрэгцээг нь шуурхай хангах чухал шийдэл болж чадсан нь бидний хувьд онцлох үр дүн байлаа. 2025 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын 40 орчим хувь нь тус "Flexi Business" бизнесийн зээлийн багцаас бүрдсэн байна.

2. Бид 2025 онд Олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох Lendable Asset Management, Kilde, DWM зэрэг байгууллагуудаас нийт 28 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн нь олон улсын нэр хүндтэй хөрөнгө оруулагчдын зүгээс бидэнд итгэл хүлээлгэсэн томоохон амжилт байлаа.
3. ЛэндМН-ийн толгой компани болох “АНД Глобал” Пти.Лтд нь Дэлхийн Банкны харьяа Олон Улсын Санхүүгийн Корпораци (International Finance Corporation) тэргүүтэй нэр хүнд бүхий хөрөнгө оруулагчдаас Series B зэрэглэлийн хөрөнгө оруулалт татсан Монголын анхны стартап компани боллоо. Энэхүү хөрөнгө оруулалт нь ЛэндМН-ээр дамжуулан Монголын бичил, жижиг дунд бизнесүүдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.
4. ЛэндМН нь 2025 оны 10 дугаар сарын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг бүрэн буюу 93% ханган ажиллалаа.
5. 2025 онд Компанийн татан төвлөрүүлсэн эх үүсвэр 28%-иар, зээлийн багц 37%-иар, хүүгийн орлого 52%-иар, цэвэр ашиг 11%-иар тус тус өсөөд байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлаар компанийн нэгж хувьцаанд 16.5 (арван зургаа аравны таван) төгрөгийн ногдол ашиг тооцон олгохоор тогтоож, 2025 оны цэвэр ашгийн 30.4 (гуч аравны дөрвөн) хувийг буюу 12,198,477,769.5 (арван хоёр тэрбум нэг зуун ерэн найман сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун жаран ес аравны таван) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлээд байна.

Ингээд “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа албан ёсоор эхлүүлж байна.

Та бүхэнд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг танилцуулъя.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах
1	Хурлын ирц бүртгэх	11:00-12:00	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	12:00-12:05	Тооллогын комиссын дарга
3	Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	12:05-12:10	Хурлын дарга
4	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах	12:10-12:20	Гүйцэтгэх захирал
5	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх	12:20-12:30	Хурлын дарга
6	Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах	12:30-12:40	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн Хараат бус гишүүн
7	Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	12:40-12:50	Хурлын дарга

8	Компанийн ТУЗ-ийн 2026 оны төсвийн саналыг танилцуулах	12:50-13:00	Гүйцэтгэх захирал
9	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	13:00-13:30	Хурлын дарга
			Гүйцэтгэх захирал,
			ТУЗ-ийн хараат бус гишүүд
10	Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах	13:30-13:50	Хурлын дарга,
			Тооллогын комиссын дарга
11	Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	13:50-14:20	Тооллогын комиссын дарга
12	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах	14:20-14:30	Хурлын дарга,
			Хурал зохион байгуулах комиссын дарга

Энэхүү дэгийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал маань явагдана.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах үндсэн 5 асуудлыг хэлэлцэнэ.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
5. Компанийн ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах;

Эдгээр асуудлуудыг хэлэлцэн батална.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хурлын дарга О.Болдбаатар танд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №1-Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулна уу** хэмээн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр таныг индэрт урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №1: КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

Компанийн Хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Бидний энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хамгийн эхний хэлэлцэх асуудал болох Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулахдаа таатай байна. За ингээд бүгдээрээ “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны онцлох үйл явдлуудыг дараах видеоноос хураангуйлан харцгаая.

(2025 оны онцлох үйл явдлын талаар видео үзүүлэв)

Ингээд та бүхэндээ 2025 оны Бизнесийн үйл ажиллагааны үр дүнг товч танилцуулъя.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд 2025 онд боломжийг бүтээсэн жил байлаа гэж харж байна. Бид яагаад тэгж дүгнэж байна вэ гэхээр та бүхэн мэдэж байгаачлан бид яг одоогоос арван жилийн өмнө буюу 2016 онд анхны бүрэн дижитал барьцаагүй хэрэглээний зээл гаргаж, финтек үйлчилгээг Монголд нэвтрүүлж байсан бол бид 2024 онд фокусаа хэрэглээний зээлээс бизнесийн бичил зээл рүү төвлөрүүлж, анх удаа бүрэн дижитал бизнесийн зээлийг Монголдоо нэвтрүүлсэн билээ. 2025 онд бид энэ стратегиа улам бататгаж, бичил жижиг дунд бизнесүүдийн санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх дээр 100% төвлөрч ажиллалаа. Үүний үр дүнд зээлийн багц маань 325 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 37% өссөн байна. Гэхдээ энэ өсөлтийн дийлэнх буюу 80% -г бизнесийн зээлийн өсөлт маань бүрдүүлж байна. Бизнесийн зээлийн өсөлтийн хурдыг дангаар харвал 123% буюу багц өөрөө дариу 2 дахин өссөн байгааг харж байна. Улмаар 2025 онд манай зээлийн багцын 40%г энэхүү бидний 2024 онд буюу 2 жилийн өмнө зах зээлд нэвтрүүлж байсан энэхүү шинэ бүтээгдэхүүн маань эзэлж байна. Мөн та бүхэн мэдэж байгаачлан, 2025 оноос хэрэглээний зээлийн олголт дээр хязгаарлалтуудыг зохицуулагч байгууллагуудаас нэлээн тавьж эхэлсэн. Үүний үр дүнд санхүүгийн салбарын дунд хэрэглээний зээлийн өсөлт нэлээн саарсан, үүнтэй амжаад бид бас 2024 онд бизнесийн зээлийн зах зээлрүү төвлөрч, сүүлийн жилийн гол өсөлтийг бизнесийн зээлийн бүтээгдэхүүнээрээ авч чадлаа.

За мөн багцын өсөлтийг дагаад, орлогыг түүхэн дээд хэмжээ буюу 135 тэрбум төгрөгт хүргэж ажиллалаа. За мөн энэ жил бидний эздийн өмч буюу та бүхний өмч 100 тэрбум төгрөгийн босгыг давлаа. За цэвэр ашгийн хэмжээ мөн энэ жил өмнөх оноосоо давж 40 тэрбум төгрөгт хүрлээ. За тоон үзүүлэлт, дэр дундаа ашгийн маржинг бүгдээрээ сүүлийн графикаас харж болно.

Энэ жилийн хувьд ашгийн маржин өмнөх онуудтайгаа харьцуулахад буурсан байгаа. Үүний гол үндсэн шалтгаан бол хэрэглээний зээлийн чанарын үзүүлэлт буурсантай холбоотойгоор зээлийн сангийн зардал нэмэгдсэн. Сангийн зардлын тооцоолол нь Олон улсын Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу хийгддэг бөгөөд зээлийн хугацаа хэтрэлттэй шууд хамааралттай байдаг. За бид хэрэглээний зээлийн энэхүү чанарын үзүүлэлтийн бууралт нь сүүлийн 3-4 жилийн санхүүгийн салбарын, зөвхөн банк бус гэлтгүй банкны салбарын хэрэглээний зээлийн хэт тэлэлттэй холбоотой гэж харж байна. Банкны салбарын цалингийн зээл ковидын дараа буюу 2022-2024 онд 2 дахин өссөн, мөн банк бусын салбарын нийт зээл мөн энэ онуудад мөн адил 2 дахин өссөнтэй холбоотойгоор хэт халалт үүссэн гэж харж байна. Мөн үүнтэй зэрэгцээд сүүлийн жилүүдэд инфлаци байнга өндөр түвшинд хадгалагдаж, ковидын дараах 20% хүрч байсан цалингийн цэвэр өсөлт өнөөдрийн байдлаар 0 хувь болж буураад байгаатай холбоотой байна. Гэсэн хэдий ч бид 2025 онд ашгийн дүн хэмжээг түүхэн дээд хэмжээнд хүргэж, улмаар энэ оны ашгаас нэгж хувьцаанд 16.5 төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр тараахаар ТУЗ-өөс шийдвэрлэлээ. Ногдол ашгийн энэ жилийн өгөөж болох 10%-г хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, салбарын бусад өрсөлдөгчидтэй харьцуулахад дариу 2-3 дахин өндөр байгааг онцолмоор байна.

2025 онд бид нийт 10,000 орчим бизнес эрхлэгч нарт хүрч үйлчилсэн бөгөөд LendMN аппликейшнаараа дамжуулан 133 мянган удаагийн олголтоор нийт 439 тэрбум төгрөгийн “Flexi Business” бизнесийн зээлийн санхүүжилтийг олгосон байна. Эдгээр бизнесүүдийн 72% нь эмэгтэй бизнес эрхлэгчид, 36% нь 35 хүртэлх насны залуу бизнес эрхлэгчид, 29% нь хөдөө орон нутагт хувиараа бизнес эрхлэгч нар байгаа нь дижитал санхүүжилт эмэгтэйчүүд, залуучууд, орон нутгийн бизнесүүдэд бодитоор хүрч байгааг харуулж байна.

Үүн дээр нэмээд онцлох нь эдгээр 10,000 бизнес эрхлэгчдийн маань 10 бизнес тутмын 4 нь анх удаа бизнесийн зээл авч байгаа бөгөөд энэ нь бид монголын жижиг дунд бизнес эрхлэгчдийн дундах санхүүгийн хүртээмжийн асуудлыг бодитоор шийдэж, сайжруулж байгааг харуулж байна.

Мөн бид 2025 онд эдгээр бичил бизнесийн харилцагчдадаа зөвхөн санхүүжилт олгохоос гадна тэдгээрийг бизнесээ явуулахад, өргөжин тэлэхэд нь тулгарч буй асуудлуудыг шийдэхийн төлөө ажиллалаа. Үүний нэг жишээ нь эдгээр жижиг бизнесүүдийн борлуулалтыг тэлж өгөх шийдэл бүхий дараа төлбөрийн зах зээл дээрх шийдлүүд маань эдгээр жижиг бизнесүүдийг орхигдуулсан байгааг анзаарч, жижиг бизнесүүдийн онцлогт тохируулан, тэдгээрийг худалдан авагчидтай нь холбосон дараа төлбөрийн шийдэл болох Lenddy бүтээгдэхүүнээ зах зээлд бас нэвтрүүлсэн.

Энэ бүхний үр дүнд манай бид 10,000 бизнес эрхлэгчдийнхээ 92% хувьд борлуулалтаа өсгөх, 1/-д нь ажлын байраа нэмэгдүүлэх боломжийг бий болгосон байна. Өөрөөр хэлбэл бид харилцагчдад санхүүжилт олгоод зогсохгүй Монгол улсын санхүүгийн зах зээлд хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгш байдлыг хангах зэрэг тогтвортой байдлын зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, өөрсдийн хувь нэмрийг оруулж байгаадаа туйлын баяртай байна.

За бидний энэхүү үйл ажиллагааг олон улсын нөлөөллийн буюу impact санхүүжилтийн байгууллагууд мөн дэмжин ажиллаж эхэллээ. Бид энэ жил Lendable, DWM and Kilde гэсэн 3 олон улсын нөлөөллийн санхүүжилтийн байгууллагаас нийтдээ 28 сая ам доллар буюу 100 тэрбум төгрөгийн урт хугацааны санхүүжилт амжилтай татан төвлөрүүлээд байна.

Дээрх санхүүгийн болон бусад тоон үзүүлэлтүүдийг хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар хянана баталгаажуулсан санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулъя.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хөндлөнгийн хараат бус аудитын компани болох “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК аудит хийж ажилласан бөгөөд энэхүү санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв тайлагнасан байна гэж хөндлөнгийн хараат бус аудитор дүгнэсэн байна. Энэ тайлан дээр харагдаж байгаачлан бид 2025 онд хүү болон түүнтэй адилтгах орлого 135.4 тэрбум төгрөг, нийт эздийн өмч 101.8 тэрбум төгрөг, цэвэр ашиг 40.1 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Та бүхэн аудитлагдсан дэлгэрэнгүй тайлантай компанийн албан ёсны веб хуудсаар орж танилцах боломжтой байгаа.

Баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяртаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хэлэлцэх асуудал №2: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай болон Хэлэлцэх асуудал №3: Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан зэргийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн С.Боргил таныг индэрт урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №2: КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хорооны дарга С.Боргил:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Та бүхэн дэлгэцээс харж байгаачлан ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлаар Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцсан.

Компанийн 2025 оны санхүүгийн тайланд Олон улсын хамгийн шилдэг аудитын компани болох “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК хараат бус аудит хийж баталгаажуулсан ба Санхүүгийн аудитлагдсан тайлангийн хувьд ямарваа нэг материаллаг зөрчил илрээгүй, Монгол Улсын болон олон улсын тайлагналын стандартын дагуу тайлан маань бэлтгэгдсэн тул ТУЗ-ийн зүгээс 26/01 тоот тогтоолоор аудитлагдсан тайланг хүлээн зөвшөөрсөн болно. Мөн Компанийн 2025 оны үйл ажиллагааг ТУЗ-ийн зүгээс “Хангалттай” хэмээн дүгнэж, 26/02 тоот тогтоолыг гаргасан байна.

Иймд өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, баталж өгөхийг Хувьцаа эзэмшигч та бүхнээс хүсэж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №3: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ТАНИЛЦУУЛАХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хорооны дарга С.Боргил:

Та бүхэнд Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь Компанийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

ТУЗ эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1/ Эрсдэл ба Байгаль орчин, нийгэм засаглалын удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон 4/ Цалин урамшууллын гэсэн 4 хороодтой үйл ажиллагаагаа явууллаа.

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас улиран сонгогдсон ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Компанийн ТУЗ нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит хурал, 9 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 59 тогтоол гаргажээ. ТУЗ-өөс гарсан бүх тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллалаа.

2025 онд Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс холбоотой талтай хийсэн нийт 8 сонирхлын зөрчилтэй хэлцэлд Компанийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна.

Энэхүү хэлцлүүд нь Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор холбоотой талаас санхүүжилт татан төвлөрүүлэхтэй холбоотой байсан.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо:

Эрсдэл ба Байгаль орчин, нийгэм засаглалын удирдлагын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, 4 удаагийн эчнээ санал хураалтаар Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Компанийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн аудитын байгууллагуудтай хийсэн гэрээний дүн 248 сая төгрөг байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хороо:

Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 1 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын томилгоо, Гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо

Цалин, урамшууллын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 1 удаа хуралдаж, Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, ажиллагсдын тэтгэврийн даатгалын болон хувьцаа эзэмшүүлэх аливаа хөтөлбөрийг судалж, сонголт хийх гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болно.

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн 2025 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг баталсан бөгөөд уг батлагдсан төсвийн хүрээнд ТУЗ нь үйл ажиллагаа явуулж, төсвийн гүйцэтгэл 96%-тай байна. ТУЗ-ийн гишүүдэд нэмэлт урамшуулал, шагнал, аливаа нөхөн олговор олгоогүй болно.

Баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт болон ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан ТУЗ-ийн Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн С.Боргил танд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хэлэлцэх асуудал №4: Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн дарга, ХЭЭХ-ын дарга О.Болдбаатарыг урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №4: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ УЛИРУУЛАН СОНГОХ ЭСЭХ

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 2024 онд ажиллаж байсан ТУЗ-ийн ердийн болон хараат бус бүх гишүүдийг улируулан сонгож, ажиллуулсан билээ. 2025 онд “ЛэндМН ББСБ” ХК нь тогтвортой өсөлтийг хадгалж чадсан чухал жил байсан бөгөөд энэ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд маань оновчтой шийдвэр гаргаж, Компанийг зөв зохистой удирдан чиглүүлж ажилласны үр дүн гэж үзэж байна.

2025 онд ажилласан Компанийн ТУЗ-ийн гишүүд Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын дагуу мэргэжлийн болон ёс зүйн алдаа дутагдал гаргалгүй, хуралдаа өндөр хувийн ирцтэй, идэвх зүтгэлтэй оролцож ажилласан бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн талаар Хувьцаа эзэмшигч болон Компанийн эрх бүхий албан тушаалтан, харилцагчдын зүгээс ямар нэг гомдол гаргаагүй болно.

Бид Компанийн сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх болон 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналуудыг харгалзан үзэж Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хорооноос 2026 онд ажиллах Компанийн ТУЗ-ийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар сонгон шалгаруулж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн болно.

Ийнхүү дараах ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчид нь Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3-т заасан Компанийн ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуурыг бүрэн хангасан, ёс зүйн өндөр төлөвшилтэй, эдийн засаг, техник, технологи болон санхүүгийн зах зээлийн мэдлэг, боловсрол хангалттай эзэмшсэн, бизнесийн салбарт амжилттай мэргэшиж байгаагаа баталж чадсан гэж үзэж ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байна.

Ингээд та бүхэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулгыг дараах бичлэгээс үзнэ үү.

(Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулга видео үзүүлэв)

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгатай танилцлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэх асуудал №5-Компанийн ТУЗ-ийн 2026 оны төсвийн саналыг танилцуулна уу** хэмээн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр таныг индэрт дахин урьж байна.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ №5: ТУЗ-ИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчид та бүхэндээ Компанийн ТУЗ-ийн 2026 оны төсвийн саналыг танилцуулж байна. 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрээр батлагдсан ТУЗ-ийн 2025 оны төсвийг бид 2026 онд өөрчлөхгүй байхаар саналыг оруулж байна.

ТУЗ-ийн 2026 оны нийт төсөв нь 196 сая төгрөг байна.

Иймд Хувьцаа эзэмшигч та бүхнийг ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах санал хураалтад саналаа өгөхийг хүсэж байна.

Баярлалаа.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Компанийн ТУЗ-ийн 2026 оны төсвийн саналыг танилцуулсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяртаа баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу **Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын хэсэг** эхэлж байна. Та бүхэн гараа өргөөд чөлөөтэй асуулт асууж, хариултаа авах боломжтой. Мөн санал хураалтын цахим системээр ирүүлсэн асуултуудыг асуух болно.

Ингээд индэрт “ЛэндМН ББСБ” ХК-ийн

ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга О.Болдбаатар,

ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн С.Боргил;

ТУЗ-ийн ердийн гишүүн, Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр

Компанийн Дэд захирал Д.Баасандорж

Компанийн Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор

Компанийн Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал Б.Наранцацрал нарыг урьж байна.

Та бүхэн өнөөдрийн хуралд оролцож байгаа албан тушаалтнуудаа хүссэн асуултаа, чөлөөтэй асуух боломжтой. Зааланд манай зохион байгуулагчид микрофонуу асуулт асуух хүмүүс рүү шилжүүлээд өгөөрэй.

АСУУЛТ/ХАРИУЛТЫН ХЭСЭГ:

Асуулт 1: Зохицуулагч байгууллагуудаас хэрэглээний зээлийн хэт халалтыг хумих бодлого баримталж эхэлсэн. Энэ нь ЛэндМН-д ямар нөлөө үзүүлж байгаа вэ? Цаашид ямар арга хэмжээ авах вэ?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

Санхүүгийн Зохицуулах Хорооноос хэрэглээний зээлийн хэт халалтыг хумих зорилгоор 2026 оны 01 сард гэнэтийн шийдвэр гаргаж, 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэхээр шийдвэрлэсэн. Бидний хувьд 2025 оноос эхлэн хэрэглээний зээлийн тэлэлтийг хумьж, бизнесийн зээлийг нэмэгдүүлэхээр ажиллаж эхэлсэн бөгөөд цаашид ч энэ хэвээрээ байлгах бөгөөд бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжсэн бизнесийн зээл рүү илүү төвлөрөн ажиллах төлөвлөгөөтэй болно. Зохицуулагч байгууллагын энэхүү шийдвэр нь ББСБ-уудын үйл ажиллагааг хязгаарлах гэхээсээ илүү иргэдийг өрийн дарамтад оруулахаас сэргийлж, ББСБ-уудыг чанаргүй зээл гаргах эрсдэлээс мөн давхар хамгаалж байгаа болно. Иймд энэхүү зохицуулалт нь аль аль талдаа ашигтай шийдэл гэж бид харж байна.

Асуулт 2: Эрсдэлийн 31 тэрбумаас хэдэн хувь нь эргэж ашигт бүртгэгдэхээр байгаа вэ? Чанаргүй зээлийн хувь буурах уу? Хугацаа хэтэрсэн зээлийн задаргааг сонсож болох уу? Чанаргүй зээл, муу зээл, анхаарал хандуулах зээл гэх мэт.

Хариулт, Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал Б.Наранцацрал:

Компанийн нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь (NPL) 2024 онд 4.3%-тай байсан нь 2025 онд 7.7% болж өссөн. Үүний гол шалтгаан нь хэрэглээний зээлээс шалтгаалсан бөгөөд бид 2025 оны эхнээс эхлэн хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлаж, бизнесийн зээлийн тэлэлтийг хийсэн. Бизнесийн зээлийн NPL-г 3.5% байгаа бөгөөд энэ нь нийт чанаргүй зээлийн багцтай харьцуулахад маш бага байгаа болно. Хэдий манай хэрэглээний зээлийн NPL өссөн хэдий ч бизнесийн зээл буюу чанартай зээлийн багц маань өсөхийн хэрээр нөлөөлөл нь бага байгаа болно. Энэхүү төлөвлөгөөгөө 2026 онд ч барьж ажиллахаар манай Менежментийн багийн зүгээс шийдвэрлээд байна.

Салбарын NPL-үүдийг харвал Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувь нь 8.4%, Финтекийн нийт зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувь нь 8.1%, арилжааны банкнуудын хэрэглээний зээлийн NPL нь 8%-тай гарсан. Ийнхүү бид салбарын дундажаас бага NPL-тэй байгаа бөгөөд цаашид ч бага байх тал дээр хичээн ажиллах болно.

Асуулт 3: 1-р асуулт, Хүүгийн орлого 135 тэрбум, цэвэр ашиг 40 тэрбумтай гарсан байна. 2026 онд хэдэн хувийн өсөлттэйгөөр хэдэн төгрөгийн багцад хүрэхээр төлөвлөж байгаа вэ? 2-р асуулт, Дэлхийн эдийн засаг болон Америк, Ираны дайнтай холбоотойгоор дизель түлшний үнэ 4,000 төгрөг гарах нь ойлгомжтой болчихлоо. Үүнтэй холбоотойгоор инфляц өснө, инфляц өсөхөөр Монголбанк бодлогын хүүгээ өсгөнө. Иймд танай бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт орох уу?

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр: Бид 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар 2026 оны төлөвлөгөөг баталсан бөгөөд энэ төлөвлөгөөний үндсэн агуулга нь Хэрэглээний зээлээс илүү Бизнесийн зээл рүү төвлөрнө гэж харж байна. 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн СЗХ-оос гаргасан хэрэглээний зээлтэй холбоотой гэнэтийн өөрчлөлт нь бидний төлөвлөгөөнд айхтар нөлөө үзүүлэхгүй байна. Бид Бизнесийн зээлийн багцаа 20-30 хувиар өсгөхөөр зорин ажиллаж байна. Гэхдээ эдийн засгийн одоогийн тогтворгүй байдал, дайны нөлөө зэрэг богино хугацаанд нөлөөлөхгүй ч урт хугацаандаа нөлөөлөх хүчин зүйлүүдийг харгалзан үзэж, эрсдэлээ тооцоолон ажиллахаар төлөвлөж байна. Ийнхүү бизнесийн зээл рүү төвлөрч байгаа хэдий ч бид одоогийн чанаргүй зээлийн

багцад эзлэх хувийг байнга барьж ажиллахыг эрмэлзэж байгаа тул 2026 он хямралттай жил байх ба 2027 он ч гэсэн сайнгүй байх тул бид энэ бүх нөхцөлийг харгалзан ажиллаж байна.

Хариулт, Бизнес хөгжлийн газрын захирал Ж.Сосор:

Нэмээд хариулахад, манай улс шатахууны хомсдолд орж байсан хамгийн сүүлийн он бол 2019 он гэж санагдаж байна. Энэ үед маш их бизнесүүдэд маш нөлөө орж ирж, бодлогын хүү өссөн, инфляцад нөлөө орж ирж байсан. Тэр үед хамгийн том нөлөө авч байсан салбарууд нь хөдөө аж ахуй, уул уурхай, барилгын салбарууд байсан. Бидний төлөвлөгөөгөөр зээл олгож байгаа, дэмжихийг хүсэж байгаа салбарууд бол худалдааны бизнес эрхэлж байгаа хүмүүс болно. Хүн байгаа цагт идэж, уух наад захын хэрэгцээгээ хангадаг учраас ямар ч цаг үед худалдааны салбарт нөлөөлөл нь харьцангуй багаар тусаж байдаг. Тийм учраас манай бизнесийн зээлд нөлөөлөл бага учирна гэж бид найдаж байна.

Асуулт 4: 2018 оноос хойш ЛэндМН-ийн хувьцааг эзэмшиж байна. 2025 онд та бүхэн их сайн ажилласан байна гэж дүгнэж байна. Ийнхүү сайн ажилласан удирдлагууд, хамт олонд нь талархал илэрхийлье. Өмнөх асуултуудтай давхцуулахгүйгээр 2-3 асуулт асууя гэж бодож байна. 1-р асуулт, 2025 онд 40 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байгаа бөгөөд 12.2 тэрбум төгрөгийг ногдол ашигт зарцуулахаар төлөвлөсөн байна. Үлдсэн цэвэр ашгийг юунд зарцуулахаар төлөвлөж байгаа вэ? 2-р асуулт, Хувьцааны ханш нэг их өсөхгүй тогтвортой байгаад байна. Энэ цаашаа өсөх үү? Өсвөл ямар үндэслэлээр өсөх вэ? 3-р асуулт, ТУЗ-ийн дарга О.Болдбаатараас асууя, ТУЗ-ийн ихэнх гишүүд олон газар зэрэг ажиллаж байна. Гүйцэтгэх захирал одоогийн байдлаар 4 газар ажиллаж байна. Ийм олон газар ажиллахад ажил цалгардахгүй юу? 4-р асуулт, Зээл олгохдоо Хувьцаа эзэмшигч нартаа хөнгөлттэй үйлчлэх журам байгаа юу? 5-р асуулт, Аудит хийсэн компани хэд дэх жилдээ хийж байгаа вэ?

Хариулт, Хурлындарга О.Болдбаатар: За би 3 болон 5-р асуултад хариулъя. 3-р асуултын хувьд, ТУЗ-ийн зөвлөлийн гишүүн маань жилд 5 удаа ээлжит хуралд, 4-5 удаа эчнээ санал хураалтад оролцож байгаа болно. Иймд ЛэндМН дээр зарцуулах цаг нь бүтэн жилээр бодвол маш бага байдаг тул тухайн хүмүүс давхар ажил хийгээд явж болж байна. ТУЗ-ийн гишүүдэд мэргэшил болон ажлын туршлагатай хүмүүсийг ажиллуулж байгаа тул асуудал үүсдэггүй болно. Гүйцэтгэх захирлын давхар гүйцэтгэж байгаа ажлуудын хувьд “ЛэндМН ББСБ” ХК-ийн доор нь байгаа охин компаниудын гүйцэтгэх захирлыг давхар хийж байгаа бөгөөд тэр нь ЛэндМН-ийн үйл ажиллагаанд хамааралтай байгаа болно. Мөн “ЛэндМН ББСБ” ХК-ийн толгой компаниуд болох “АНД Системс” ХК болон “АНД ФСЖ” Пти.Лтд-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа бөгөөд эдгээр компаниуд нь мөн л ЛэндМН-ийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай компаниуд болно. Гүйцэтгэх захирлын өдөр тутмын ажил нь 100% ЛэндМН рүүгээ төвлөрч байгаа бөгөөд үүний хажуугаар давхар өөр компанид ажилдаггүй тул асуудалгүй гэж харж байна. 5-р асуултын хувьд, Аудитын компанийн хувьд Дэлхийн 5 том аудитын компанийн нэг “Эрнст энд Янг Монголия” ХХК ажиллаж байгаа бөгөөд тус компанитай бид 2018 оноос эхлэн хамтарч ажиллаж байгаа бөгөөд Аудитын тухай хуульд заасны дагуу өнгөрсөн 3 жилийн хугацаанд үндсэн аудитораар ажиллуулаагүй болно. Аудитын компанийг сонгохдоо нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож, аудитын компаниудаас үнийн санал аваад ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо сонгон шалгаруулалт хийгээд явж байна. 2026 оны аудитын компанийг удахгүй сонгохоор ажиллаж байна.

Хариулт, Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр:

Бид 40.1 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас бид 12.2 тэрбум төгрөгийг нь ногдол ашгаар тарааж байгаа бөгөөд үлдсэн 28 орчим тэрбум төгрөгийг бизнесийн эргэлтийн хөрөнгийн зориулалтаар ашиглахаар байна. Компанийн эздийн өмчийн өгөөж 40-50%-тай байдаг.

Тэгэхээр буцаагаад бизнес рүүгээ хийх нь ашигтай гэж харж байна. Хувьцааны ханш өсөх үү гэдэг дээр Гүйцэтгэх удирдлагын хувьд Компанийн бизнесийг өсгөх, үр ашигт ажиллагааг сайжруулах, буцаагаад хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны үнийг өсгөх үндсэн зорилготой ажиллаж байна. Компанийн хувьд халаасны хувьцаа авч, хувьцааны ханшид нөлөөлөх үйл ажиллагааг хийхгүй, үндсэн бизнесийн үйл ажиллагааны тэлэлт дээр илүү анхаарч ажиллаж байна. Хувьцаа өсөх нь зах зээлийн журмаараа явах бөгөөд Компани өөрөө өсөж байгаа цагт хувьцаа өсөх хандлагатай байдаг. Хувьцаа эзэмшигчдээ хөнгөлөлттэй зээл олгох уу гэдэг асуултын хувьд одоогоор бидэнд тийм зээлийн бүтээгдэхүүн байхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдэдээ манай хэрэглэгчдэдээ санал болгож буй зээлийн хүүгийн түвшинг санал болгоод, зээл олгоод явж байна.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын хэсэг өндөрлөлөө. Та бүхэн асууж амжаагүй асуулт байвал санал хураалтын дараагаар манай компанийн удирдлагууд, ТУЗ-ийн гишүүдээс биечилж асуух боломжтой байгаа. Одоо харин хэлэлцэж буй асуудлаар санал хураах үе шат эхэллээ.

САНАЛ ХУРААЛТЫН ХУГАЦАА 20 МИНУТ.

Одоо бүгдээрээ САНАЛ ӨГӨХ ЗААВАР-тай танилцъя.

(Хэлэлцэж байгаа асуудалд *санал өгөх заавар бичлэг үзүүлэв*)

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

ХЭЛЭЛЦЭЖ БАЙГАА АСУУДЛУУДААР САНАЛ ХУРААЖ ДУУСЛАА.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах хэсэг эхэлж байна. Индэрт тооллогын комиссын дарга С.Батбуяныг урьж байна.

Тооллогын комиссын дарга С.Батбуян:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэж дууслаа. Тооллогын комиссын бүрэлдэхүүнд миний бие С.Батбуян, гишүүд Д.Шүрэнцэцэг, Э.Билгүүн, Х.Хулан гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулбал:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой дараах санал хураалтын дүнг Хувьцаа эзэмшигчдийн хурлын гишүүдэд танилцуулсугай.

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд улиран сонгогдох нэр дэвшигчид өгсөн санал хураалтын дүн:
 - 1.1. О.Болдбаатар **601,193,745** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.67%**;
 - 1.2. Б.Хос-Эрдэнэ **600,773,329** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.66%**;
 - 1.3. Ц.Ууганбаяр **601,779,981** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.68%**;
 - 1.4. П.Отгонбаяр **600,579,114** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.65%**;
 - 1.5. С.Энх-Амгалан **600,511,351** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.65%**;

- 1.6. Кацухико Мадоно **602,268,454** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **16.70%** байх тул Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд улиран сонгогдох нэр дэвшигчид өгсөн санал хураалтын дүн:
 - 2.1. С.Нэргүй **601,431,435** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **33.35%**;
 - 2.2. Х.Батсүрэн **600,977,499** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **33.32%**;
 - 2.3. Ц.Түмэнцогт **601,144,053** ширхэг хувьцааны санал буюу ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгсөн нийт саналын **33.33%** байх тул Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй.
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудалд өгсөн нийт **71** ширхэг саналын эрх бүхий энгийн хувьцааны санал хураалтын дүн:
 - 3.1 Зөвшөөрсөн **601,169,914** ширхэг хувьцааны санал буюу **99.99%**;
 - 3.2 Татгалзсан **0** ширхэг хувьцааны санал буюу **0.00%**;
 - 3.3 Түдгэлзсэн **17** ширхэг хувьцааны санал буюу **0.0000%** байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэр хүчинтэй.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг батлах тухай асуудалд өгсөн нийт **71** ширхэг саналын эрх бүхий энгийн хувьцааны санал хураалтын дүн:
 - 4.1. Зөвшөөрсөн **601,069,908** ширхэг хувьцааны санал буюу **99.98%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд 99.98% гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов);
 - 4.2. Татгалзсан **100,001** ширхэг хувьцааны санал буюу **0.02%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд 0.02% гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов);
 - 4.3. Түдгэлзсэн **22** ширхэг хувьцааны санал буюу **0.00%**
(Санал хураалтын систем нь санал хураалтын дүнг 0.00 орноор нарийвчилж тооцоолдогтой холбоотойгоор системд 0.00% гэж харагдах бөгөөд хувь хэмжээг нарийвчлан тооцоолов) байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу хуралд

саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэр хүчинтэй.

Хоёр. Хэлэлцэх асуудалтай холбоотой хүчингүй болсон саналын хуудас байхгүй болохыг баталгаажуулсугай. Үүнд:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох санал хураалтад хүчингүй болсон саналын хуудасны тоо **0** ширхэг буюу **0.00** хувийн санал;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох санал хураалтад хүчингүй болсон саналын хуудасны тоо **0** ширхэг буюу **0.00** хувийн санал;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах санал хураалтад хүчингүй болсон саналын хуудасны тоо **0** ширхэг буюу **0.00** хувийн санал;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах санал хураалтад хүчингүй болсон саналын хуудасны тоо **0** ширхэг буюу **0.00** хувийн санал;

Гурав. Хувьцаа эзэмшигчид 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цаг хүртэл брокер, дилерийн компаниудаар дамжуулан санал өгөх боломжтой байсан бөгөөд Тооллогын комиссоос шалгаж үзэхэд 1 брокерын компаниас 1 (нэг) хувьцаа эзэмшигчийн Саналын хуудас А болон Б-г ирүүлснийг Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт заасны дагуу хүчинтэйд тооцож, саналыг бүртгэсэн болохыг тэмдэглэсүгэй.

Ийнхүү тооллогын комиссын тогтоолыг гаргаж 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “ЛэндМН ББСБ” ХК-ийн ХЭЭХ-ын санал хураалтын дүнг баталгаажуулж байна.

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын шийдвэрийг баталлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа Эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах хэсэг эхэлж байна. Хэлэлцсэн асуудлуудтай холбоотой санал хураалтын дүнд үндэслэн хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг танилцуулна уу хэмээн Хурлын дарга О.Болдбаатар таныг индэрт дахин урьж байна.

ХЭЭХ-ын дарга О.Болдбаатар:

ХЭЭХ-аас гарсан шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

(ХЭЭХ-аас гарсан шийдвэрийг хавсаргав)

ХЭЭХ зохион байгуулах комиссын дарга М.Түвшинжаргал:

Нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажилладаг байгууллагууд, бүх харилцагч та бүхэндээ баярлалаа. “ЛэндМН ББСБ” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 9 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Бидний хамт олон 2026 онд улам хичээн ажиллах болно.

Бидэнд үргэлж итгэл хүлээлгэж, дэмжин ажилладаг нийт харилцагчид, хамтран ажилладаг аж ахуйн нэгж, албан байгууллагууд болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Дараа жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дахин уулзацгаая.
Баяртай.



ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

О.БОЛДБААТАР

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга

М.ТҮВШИНЖАРГАЛ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал,
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын дарга

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Х.ХУЛАН

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нарийн бичгийн дарга